

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 02 ДУГААР САРЫН 01 ДЭХ
ДОЛОО ХОНОГИЙН МЭДЭЭ**

2018.02.01

	Хоногийн товч мэдээ	Дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	Бусад асуудал
1	Толбо сумын “Сайр” ууланд Дэлхийн байгаль хамгаалах сангийн монгол дахь хөтөлбөрийн газрын Ховд аймаг дахь салбарын санхүүжилтээр “Сайр тур оргил” нөхөрлөлтэй хамтран Монгол улсын улаан номд орсон Янгир ямаад зориулан 4 хэсэг газарт 200 ширхэг боодол өвс тавьж биотехникийн арга хэмжээ авлаа.		
2	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн 2017 оны биелэлтийг гаргаж аймгийн ЗДТГ-ын ХОХБХэлтэст хүргүүлэв.		
3	Бугат сумын “Төмөрт”, “Тошинт-хатуугийн гол” Толбо сумын “Зурхайчин”, Улаанхус сумын “Баянзүрх”, агнуурын бүс нутгуудын менежментийг хариуцагч Монгол сафари ХХК нь 1000000 төгрөг гаргаж тус сумдын ЗДТГазар, БОАЖГазар, нөхөрлөлүүдийн гишүүдэд хамтран зэрлэг ан амьтад зориулан өвс, давс тавьж биотехникийн арга хэмжээ авах ажлыг зохион байгуулав.		
4	Аймгийн хэмжээний ан амьтны өвөлжилтийн байдлын талаар орон нутгийн радио, телевизээр мэдээлэл өглөө.		
5	Байгууллагын ХАСХОМ мэдүүлэх өгөх албан тушаалтнуудын хөрөнгө оруулах мэдүүлэхийг Авилгатай тэмцэх газрын мэдээллийн санд цахимаар оруулан баталгаажуулав.		
6	<p><u>Өнгөрсөн долоо хоногт өгөгдсөн үүрэг даалгаврын талаар мэдээлэл</u></p> <p align="center">БАЯН-ӨЛИЙ АЙМГИЙН АН АМЬТНЫ ӨВӨЛЖИЛТИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ</p> <p>Аймгийн уулархаг газарт их хэмжээний цас орж, цаг агаар хүйтэрч зэрлэг амьтны өвөлжилтийн байдал хүндрээд байна.</p> <p>Тус аймагт байгаа ан амьтны өвөлжилтийн байдал нэлээд хүндэрч дэлхийн болон Монгол улсын улаан номонд орсон Аргаль хонь, Янгир ямаа, Халиун буга зэрэг амьтад уулнаас бууж, малтай хамт бэлчиж, бэлчээр хомсдож идээшлэх байдал хүнд байна.</p> <p>Туурайтан амьтадын амьдрах орчин хомсдож хоол тэжээлгүйгээс тамирдаж, тураалд орж чоно нохойд бариулах, осгож үхэх асуудал гарч байна.</p> <p>Одоогийн байдлаар Булган сумын газар нутагт Буга 1, Янгир ямаа 4 толгой, хорогдож, тус сумын байгаль хамгаалагч 1 толгой янгир</p>		

	<p>ямааг хашаанд тэжээж байна.</p> <p>Толбо сумын “Борт” уулнаас 2 толгой янгир ямаа, Ногооннуур сумын “Дэвлийн арал”-аас 1 толгой зэрлэг гахай, Бугат сумын “Төмөрт” агнуурын бүс нутгаас 2 толгой угалз, Алтай сумаас 5 толгой Аргаль хонь, Улаанхус сумын “Баянзүрх” агнуурын бүс нутгаас 2 толгой угалз, Дэлүүн сумын “Бүргэд”-ийн улнаас 3 толгой янгир янгир ямаа, Буянт сумаас 11 аргаль хонь Нийт 1 буга, 9 янгир ямаа, 20 тус тус хорогдод байна.</p> <p>Ан агнуурын менежментийн төлөвлөгөөний дагуу өвөлжилт хүндэрч зэрлэг ан амьтны бэлчээр хомсдож байгаатай холбогдуулан Монгол Алтай таван богд, Шивэт хайрхан, Сийлхэмийн А, Б хэсэг, Толбо сумын Борт, Бургаст, Хурайт, Харасай, Бөрөгтэйн уул, Сайр уул Алтай сумын Халуун бардам, Буянт сумын Чулуун хашаа, Мандах гол, Дэлүүн сумын Ахуунт, Улаан говь гэх газруудад зэрлэг ан амьтанд зориулан биотехникийн арга хэмжээ авах ажлыг МАНУТХГЗахиргаа болон Алтай, Толбо, Буянт, Дэлүүн сумдын ЗДТГазартай хамтран зохион байгуулав.</p> <p>Монгол сафари ХХК-тай хамтран менементийг хариуцаж буй агнуурын бүс нутаг Бугат сумын “Төмөрт”, Улаанхус сумын “Баянзүрх” агнуурын бүс нутагт 250,0 мян төг, Толбо сумын “Зурхайчин” агнуурын бүс нутагт 250,0 мян төгрөг, Бугат сумын “Тошинт-хатуугийн гол” агнуурын бүс нутагт 500,0 мян төгрөгийн биотехникийн арга хэмжээ авч Толбо сумын “Сайр ” ууланд Дэлхийн байгаль хамгаалах сангийн хөтөлбөрийн газрын санхүүжилтээр 200 ширхэг боодол өвс тавьж биотехникийн арга хэмжээ авсан. Аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар 15 агнуурын бүс нутаг байна. Тус агнуурын бүс нутагуудын менежментийг хариуцагч компани хариуцаж буй агнуурын бүс нутагт биотехникийн арга хэмжээг сумдын Засаг даргын тамгын газарт хамтран зохион байгуулав.</p> <p>Цаашид цас нэмж орж, цаг агаар хүйтрэх бол ан амьтны өвөлжилт хүндрэх аюултай байгаа учираас ан амьтанд өвс тэжээл тавьж биотехникийн арга хэмжээ авах талаас анхарч өгөхийг хүсэж байна.</p> <p>Мөн Ногооннуур сумын “Бахлаг”, Толбо сумын “Сайр”, “Борт”, Ногооннуур сумын “Ямаат”, Сагсай сумын “Көксай”, Улаанхус сумын “Их ойгор”, “Усай живэт”, “Баян уул”, Цэнгэл сумын “Бор бургасан”, “Мухар”, Алтай сумын “Шар говь” Дэлүүн сумын “Бүргэд уул” гэх газруудад биотехникийн арга хэмжээ авах шаардлагатай учираас 6.328.000 сая төгрөг шийдвэрлэж өгөхийг хүсье.</p>		
--	---	--	--

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

